

# Намар, өвлийн вакцин

## Эдгээр вакцин яагаад чухал вэ?

КОВИД-19, томуу, амьсгалын замын синцитиал вирусийн (АЗСВ) эсрэг вакцин хүндээр өвчлөх эрсдэлийг бууруулдаг. Та бүх гурван вакциныг нэгэн зэрэг хийлгэх боломжтой.

## Вакцин

## Хэн үүнийг хийлгэх хэрэгтэй вэ?

### Томуу



Томуугийн вирусийн 4 омгоос хамгаална.

**6 сар ба түүнээс дээш насны хүн бүр**, өндөгний харшилтай хүмүүс хүртэл нэг тунг хийлгэх хэрэгтэй.

**8 ба түүнээс доош насны хүүхдүүд** эхний улиралдаа хоёр тунг хийлгэх хэрэгтэй.

### КОВИД-19



Омикроны дэд хувилбар болох ХВВ-ээс сэргийлэхээр шинэчилсэн.

Шинэчлэгдсэн Модерна, Пфайзер, Новавакс үйлдвэрийн вакцин хийлгэх боломжтой.

**6 сар ба түүнээс дээш насны хүн бүр** сүүлийн тунгаа хийлгэснээс хойш дор хаяж 2 сарын дараа шинэчилсэн КОВИД-19 өвчний вакцин хийлгэхийг ӨХТ зөвлөж байна.

- Хэзээ ч вакцин хийлгэж байгаагүй ихэнх хүмүүс Пфайзер/Модерна үйлдвэрийн нэг тунг ЭСВЭЛ Новавакс үйлдвэрийн хоёр тунг хийлгэх хэрэгтэй.
- Хэзээ ч вакцин хийлгэж байгаагүй 6 сартайгаас 4 хүртэлх насны хүүхдүүдэд КОВИД-19 өвчний хоёр эсвэл гурван тунг вакцин хийлгэх нь зүйтэй.

### АЗСВ<sup>1</sup>



Амьсгалын замын синцитиал вирусээс (АЗСВ) сэргийлнэ. АЗСВ нярай хүүхэд, өндөр настнуудад амьсгалын замын хүнд өвчин үүсгэдэг.

**60 ба түүнээс дээш насны насанд хүрэгчид** АЗСВ-ийн эсрэг вакцины талаар эмч/эм зүйчээсээ асуух хэрэгтэй.

**Жирэмсэн хүмүүс** АЗСВ идэвхэждэг улирлын турш 32-36 долоо хоногийн хооронд нэг тунг хийлгэх хэрэгтэй. (хүүхэд төрснөөс хойш хэдэн сар өвчнөөс сэргийлнэ.)

<sup>1</sup> Хэрэв жирэмсэн хүн АЗСВ-ийн эсрэг вакцин хийлгээгүй бол нярайд АЗСВ моноклональ эсрэгбиеийн нэг тунг хийх нь зүйтэй. 19 сар хүртэлх өндөр эрсдэлтэй нярай/бага насны хүүхдэд мөн нэг тунг хийх хэрэгтэй.



ALAMEDA COUNTY HEALTH CARE SERVICES AGENCY  
PUBLIC HEALTH DEPARTMENT

Дэлгэрэнгүй мэдээлэл авахаар  
[covid-19.acgov.org/vaccines](https://covid-19.acgov.org/vaccines)  
вэбсайтыг үзнэ үү.  
эсвэл QR кодыг уншуулна уу:



Таны эпидемиологич, КНЭМГ-ын танилцуулга <https://eziz.org/assets/docs/IMM-1481.pdf> дахь Кателин Жетелина, Кэйтлин Риверс нарын боловсруулсан “**2023 оны намрын вакцин**” товхимлоос авав.